



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 172


Улаанбаатар хот

### Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан иргэнд “Ард даатгал” ХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгогдсон иргэнд “Ард даатгал” ХК-аас бусад даатгалын компанид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхгүй болохыг анхааруулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 6 дугаар сарын 26-ны  
өдрийн 172-р тогтоолын хавсралт

УХА0410 5043239

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх

№	Овог	Нэр	Регистерийн дугаар	Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр	Хаяг, Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэр
1	Пүрэвсүрэн	Эрдэнэбаяр	ЛД85111716	Улаанбаатар хот	Хаяг: УБ хот, БЗД, 1 дүгээр хороо, 12 дугаар хороолол, 20/2 дугаар байр, 10 тоот. Утас: 91006000	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, хөрөнгийн, автотээврийн хэрэгслийн, мал амьтдын, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал